**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 29 өдөр | Дугаар А/194 | Хэрлэн сум

# "Тариаланчдын зөвлөгөөнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2 дугаар хуралдааны "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 06 дугаар, 2023 оны 18 дугаар хуралдааны "Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" 2 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Тариаланчдын зөвлөгөөн 2023" арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 1,610,000 (сая зургаан зуун арван мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3.Шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, ажлын гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Энх-Амгалан)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
...03... дугаар сарын..29..-ны өдрийн
А/194...дугаар захирамжийн хавсралт

| № | Зардлын төрөл | Хэмжих нэгж | Тоо | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Өдрийн хоол | х/тоо | 40 | 20000 | 800000 |
| | Цайны завсарлага | х/тоо | 40 | 6000 | 240000 |
| 2 | Анонс | м2 | 3х4 | 15000 | 180000 |
| 3 | Сургалт зохион байгуулах багшийн хөлс | цаг | 4 | 50000 | 200000 |
| 4 | Буудал | х/тоо | 1 | 120000 | 120000 |
| 5 | Багш нарын замын зардал | х/тоо | 2 | 35000 | 70000 |
| | **НИЙТ** | | | | **1,610,000** |